



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/47

Мандалговь

Сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг
төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх
тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1 дүгээр зүйлийн 1.2, 2 дугаар зүйлийн 2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн хэмжээнд хүчирхийлэлд өртөх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, өсвөр үе, залуу гэр бүл, залуучуудыг дэмжих, тэдгээрт чиглэсэн нөлөөллийн ажлыг 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд "Говийн манлайлагч бүсгүйчүүд" ТББ-аар гүйцэтгүүлсүгэй.

2. Үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд шаардагдах 12,327,500 (Арван хоёр сая гурван зуун хорин долоон мянга таван зуу) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг ханган, үр дүнтэй зохион байгуулж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ажлын хэсгийн ахлагч (Б.Бүжинлхам), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааг чанартай зохион байгуулан, хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ажлын хэсгийн ахлагч (Б.Бүжинлхам)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

480190097

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн
А/17 дугаар тушаалын дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч

Б.Бүжинлхам
Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Ц.Идэр-Оргил
Залуучуудын хөгжлийн төвийн оролцоо
хариуцсан ажилтан

Б.Мөнх-Оргил
Архив, бичиг хэрэг, олон нийт
хариуцсан ажилтан

-----oOo-----

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн
А/47 дугаар тушаалын дүгээр хавсралт



№	Үйл ажиллагааны чиглэл	Төсөв / төгрөгөөр/
1	Хүчирхийлэлд өртөх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	8,500,000.0
2	Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан, өсвөр үе, залуу гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжих, тэдгээрт чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулах	3,827,500
Нийт: 12,327,500		

-----oOo-----